



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 761

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй, 8 нэрийн, нийт 52,458,300.00 (тавин хоёр сая дөрвөн зуун тавин найман мянга гурван зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга Б.Эрдэнэваанчигт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



123007158
35-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн
761 дугаар тогтоолын хавсралт

СПОРТЫН АНАГААХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1.Машин тоног төхөөрөмж							
1	Хөргөгч / AKIRA /	2021-01-04	1	ш	176,000.00	176,000.00	-
2	Компьютер Dell OP 30	2020-06-30	1	ш	244,700.00	244,700.00	-
3	Дэлгэц Dell 19 инч	2021-01-04	1	ш	57,600.00	57,600.00	-
4	Компьютер / Dell Opt30	2021-01-04	2	ш	660,000.00	1,320,000.00	-
5	Компьютер / Dell 3050 i5. 7generation /	2018-12-31	1	ш	1,550,000.00	1,550,000.00	-
6	Лазер Эмчилгээний аппарат / Skanlab Laser Pro /	2017-12-01	1	ш	15,500,000.00	15,500,000.00	-
7	Физик эмчилгээний аппарат /Storz Master puls 100 /	2017-12-01	1	ш	33,500,000.00	33,500,000.00	-
	Дүн		8		51,688,300.00	52,348,300.00	-
2.Тавилга эд хогшил							
8	Дугуйтай сандал /хар т/	2020-06-30	7	ш	15,714.29	110,000.00	-
	Дүн		7		15,714.29	110,000.00	-
			15		51,704,014.29	52,458,300.00	-
	Нийт дүн				(тавин нэгэн сая долоон зуун дөрвөн мянга арван дөрвөн төгрөг хорин есөн мөнгө)	(тавин хоёр сая дөрвөн зуун тавин найман мянга гурван зуун)	